



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 01 сарын 29 өдөр

Дугаар 24/02

Арвайхээр сум

Журам батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.2, 35 дугаар зүйлийн 35.1.13, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх, шинэчилсэн үнэлгээ тогтоох журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Журам батлагдсантай холбогдуулан дор дурдсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг аймгийн Засаг дарга, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Орон нутгийн өмчийн газарт үүрэг болгосугай:

2.1. Аймгийн Засаг даргад үүрэг болгох нь:

- 2.1.1. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдэл хорогдлын шимтгэлээрээ балансын үнээ нөхсөн, сэргээн засварлаж цаашид ашиглах боломжгүй болох нь тогтоогдсон тавилга, эд хогшил, компьютер, тоног төхөөрөмж, түүний дагалдах хэрэгсэл, программ хангамж, ном, бусад хөрөнгөд бүртгэлтэй хөдлөх үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах асуудлыг судлан, тухай бүр акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох;
- 2.1.2. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эзэмшилд бүртгэлтэй үл хөдлөх хөрөнгө, инженерийн болон нийтийн эзэмшлийн байгууламж, газар эзэмших, ашиглах эрхтэй холбоотой актлах, худалдах, шилжүүлэх, орон нутгийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр бий болсон бараа, ажил үйлчилгээний эзэмшигчийг тогтоох, асуудлыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тухай бүр оруулан шийдвэрлүүлэх;
- 2.1.3. Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрх мэдлийн хүрээнд хамаарах төсөвт байгууллагын хооронд үл хөдлөх хөрөнгөөс бусад хөдлөх үндсэн хөрөнгө шилжүүлэх хүсэлтийг судлан, зөвшөөрөл олгох;
- 2.1.4. Орон нутгийн өмчит хуулийн этгээдэд ашиглагдаж байсан ашиглалтын хугацаа дууссан, илүүдэлтэй тээврийн хэрэгслийг худалдах, шилжүүлэх асуудлыг шийдвэрлэх;

822401006

2.2 Аймгийн Орон нутгийн өмчийн газарт үүрэг болгох нь:

- 2.2.1. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй боловч үндсэн хөрөнгийн шинжийг агуулаагүй, элэгдэл тооцоход тохиромжгүй хөрөнгийг эргэлтийн хөрөнгийн дансанд шилжүүлэх, эргэлтийн хөрөнгөд бүртгэлтэй, үндсэн хөрөнгийн шинжийг агуулсан хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлэх, үндсэн хөрөнгийн дансны ангилал хооронд шилжүүлэх асуудлыг судлан, тухай бүр зөвшөөрөл олгож байх;
- 2.2.2. Орон нутгийн өмчит байгууллагуудын акталж, данснаас, хасахаар шийдвэрлэж, зөвшөөрөл авсан боловч ашиглалтын шаардлага хангаж байгаа, элэгдлээрээ өртгөө нөхсөн боловч дахин ашиглах боломжтой, түүнчлэн өртгөө нөхөөгүй боловч гэмтсэн, засаж сэлбэн өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох, өмч хамгаалах байнгын зөвлөлийн тэмдэглэл, дүгнэлт, саналыг судлан, зөвшөөрөл олгож байх;
- 2.2.3. Төсөвт байгууллага нь нэмэлт төсөв, давсан орлого, холбогдох төсөл арга хэмжээний хүрээнд хөрөнгө худалдан авах тохиолдолд төсөв зарцуулах эрх бүхий байгууллагын шийдвэрийг үндэслэн зөвшөөрөл олгож байх;
- 2.2.4. Орон нутгийн өмчид бүртгэлтэй үл хөдлөх хөрөнгө, инженерийн болон нийтийн эзэмшлийн байгууламж, газар эзэмших, ашиглах эрхтэй холбоотой асуудлыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд, дээрхээс бусад үндсэн хөрөнгийг шийдвэрлүүлэх асуудлыг аймгийн Засаг даргад уламжлан шийдвэрлүүлж байх;
- 2.2.5. Энэхүү тогтоолыг Орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хүргүүлэх, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх, саналыг хянаж, шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулж, хяналт тавьж ажиллах;
- 2.2.6. Энэхүү тогтоолоор өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын зөвлөлийн хуралдаанд танилцуулж байх.

3. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд Зөвлөх нь:

- 3.1.1. Сумын орон нутгийн өмчит хуулийн этгээдийн (аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас суманд шилжүүлсэн) үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдэл хорогдлын шимтгэлээрээ балансын үнээ нөхсөн, сэргээн засварлаж цаашид ашиглах боломжгүй болох нь тогтоогдсон үл хөдлөх болон хөдлөх үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, асуудлыг судлан, тухай бүр шийдвэрлэж байх;
- 3.1.2. Сумын орон нутгийн хөгжлийн сан, сум хөгжүүлэх сангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажил, нийлүүлэгдсэн бараа үйлчилгээний эзэмшигчдийг тогтоох;
- 3.1.3. Сумын орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг

байгууллага хооронд шилжүүлэх, аймаг, төрийн өмчид шилжүүлэх асуудлыг судалж шийдвэрлэж байх;

3.1.4.Суманд шийдвэрлэгдэж байгаа хөрөнгөтэй холбогдолтой тогтоол шийдвэрийг Орон нутгийн өмчийн газарт хүргүүлэх, хэрэгжилтийг хангуулах;


4.“Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ыг мөрдөж ажиллахыг орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагуудад үүрэг болгосугай.

5.“Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх, шинэчилсэн үнэлгээ тогтоох журам”-ыг жишиг болгон ашиглахыг орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдлагад зөвлөсүгэй.

6.Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (И.Доржсүрэн)-д даалгасугай.

7.Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны “Журам шинэчлэн батлах тухай” 25 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай

ДАРГА



О.ПҮРЭВДОРЖ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2024 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн
24/02 дугаар тогтоолын хавсралт

ОРОН НУТГИЙН ӨМЧИД ЭД ХӨРӨНГӨ ОЛЖ АВАХ, БҮРТГЭХ, ДАНСНААС ХАСАХ, ШИЛЖҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь орон нутаг өөрийн өмчөөр дангаараа байгуулсан орон нутгийн өмчит хуулийн этгээд үндсэн хөрөнгөд хамаарах үл хөдлөх болон хөдлөх хөрөнгө (цаашид “эд хөрөнгө” гэх) олж авах, бүртгэх, худалдах, данснаас хасах, шилжүүлэх болон холбогдох шийдвэрийг хэрэгжүүлэх, биелэлтийг тооцож, тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Орон нутгийн өмчит хуулийн этгээд нь эд хөрөнгө олж авах, бүртгэх, худалдах, акталж данснаас хасах, шилжүүлэх тухай саналаа энэ журамд заасны дагуу аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газарт тавьж шийдвэрлүүлнэ.

1.3. Орон нутгийн өмчийн газар орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгө олж авах, бүртгэх, шилжүүлэх, худалдах, актлах талаар ирүүлсэн саналыг хянан үзээд энэ журамд заасны дагуу зохих байгууллагаар шийдвэрлүүлж, шийдвэрийг тухайн байгууллагад хүргүүлнэ.

1.4. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эрх барих байгууллага болон Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралдаанаар эд хөрөнгө олж авах, бүртгэх, балансаас балансад шилжүүлэх, худалдах, актлах тухай асуудлыг хэлэлцэхэд энэхүү журмыг удирдлага болгоно.

1.5. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн өмч хамгаалах Байнгын зөвлөл үйл ажиллагаандаа энэхүү журмыг баримтлан ажиллана.

1.6. Хөрөнгө данснаас хасах, шилжүүлэх, хувьчлах ажлыг “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжид заасныг үндэслэн шийдвэрлэнэ.

Хоёр. Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэхэд бүрдүүлэх материал

2.1. Орон нутгийн өмчит хуулийн этгээд нь энэ журмын 1.2-т заасан асуудлыг шийдвэрлүүлэхдээ дор дурдсан бичиг баримтаас тухайн харилцаанд хамааралтай баримт, материалыг бүрдүүлнэ:

- 2.1.1 Компанийн хувьд Төлөөлөн Удирдах зөвлөлийн, шаардлагатай бол хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр, бусад орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хувьд төсвийн ерөнхийлөн захирагч эсхүл харьяа дээд байгууллага, Орон нутгийн өмчийн газрын зөвшөөрөл;
- 2.1.2 Худалдан авах санхүүжилтийн эх үүсвэрийг баталсан эрх бүхий байгууллагын шийдвэр;
- 2.1.3 Хуулийн этгээдийн өмч хамгаалах Байнгын зөвлөлийн тэмдэглэл, дүгнэлт;
- 2.1.4 Холбогдох мэргэжлийн байгууллагын акт, дүгнэлт;
- 2.1.5 Эдийн засгийн тооцоо, үндэслэл, зах зээлийн үнийн харьцуулсан судалгаа, худалдан авах дээд, худалдах доод үнийн санал;
- 2.1.6 Балансаас балансад шилжүүлэх бол өмч эзэмшигч байгууллагын зөвшөөрөл болон шилжүүлэн авах хуулийн этгээдийн хүсэлт;

- 2.1.7 Ашиглалтын хугацаа дуусаагүй, үлдэгдэл өртөгтэй боловч ашиглах боломжгүй болсон үндсэн хөрөнгийн эвдрэл, гэмтлийн шалтгааныг тогтоосон дүгнэлт, хохирол барагдуулсныг нотлох баримт, сэргээн засварлаж ашиглахад шаардагдах эдийн засгийн тооцоо үндэслэл;
- 2.1.8 Үл хөдлөх хөрөнгийг худалдах, үнэлгээг шинэчлэн тогтоох зорилгоор эрх бүхий этгээдээр хийлгэсэн хөрөнгийн үнэлгээний тайлан;
- 2.1.9 Үндсэн хөрөнгөд бүртгэлтэй номыг устгах талаар гаргасан холбогдох мэргэжлийн байгууллагын дүгнэлт;
- 2.1.10 Үндсэн хөрөнгөд бүртгэлтэй буу, галт зэвсгийн талаар Цагдаагийн байгууллагын албан бичиг, дүгнэлт;
- 2.1.11 Түүх, соёлын дурсгалт зүйлсийн талаарх аливаа шийдвэрийг гаргахад соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын санал;
- 2.1.12 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн биет болон биет бус хөрөнгийн ашиглалтын хугацааг тогтоосон хэсгийг хуулбарлан, хуулбар үнэн тэмдгээр баталгаажуулан ирүүлэх;
- 2.1.13 Тухайн хөрөнгийн бүртгэлийн статистик мэдээллийн ТӨХ маягт;
- 2.1.14 Бусад шаардлагатай баримт материал;
- 2.2. Үл хөдлөх хөрөнгийн хувьд энэхүү журмын 2.1-д зааснаас гадна дараах баримт, мэдээллийг ирүүлнэ;
- 2.2.1. Үл хөдлөх хөрөнгө байрлаж буй газрын эзэмших (ашиглах) эрхийн гэрчилгээ, газар эзэмшүүлэх (ашиглуулах) гэрээ, кадастрын зургийн хуулбар;
- 2.2.2. Үл хөдлөх хөрөнгөд хийсэн их болон урсгал засварын зардал, тухайн эд хөрөнгөтэй холбоотой бусдын өмнө хүлээсэн хариуцлагын (зээл, өрийн барьцаа, баталгаа гэх мэт) болон ашиглалтын талаарх мэдээлэл;
- 2.2.3. Барилгын паспортын хуулбар, орчны тойм зураг, байгуулалтын зураг (план), гадна, дотор талын өнгөт фото зураг, инженерийн шугам сүлжээний техникийн зургийн хуулбар, бусад баримт бичиг;
- 2.2.4. Үл хөдлөх хөрөнгийг бусад этгээдтэй хамтарч эзэмшиж, өмчилдөг бол тухайн барилгыг бүхэлд нь зураглан, хөршүүдтэй хамтран баталсан заагийн хуулбар;
- 2.2.5. Үл хөдлөх хөрөнгийг худалдах, шилжүүлэх бол түүнд ноогдох газрын хэмжээ, гэрчилгээ, кадастрын зургийн хуулбар /салгаж хийлгэсэн/;
- 2.2.6. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эзэмшиж, ашиглаж буй газрын нэгж талбарыг хуваах, нэгтгэх, шилжүүлэх зэргээр өөрчлөлт орж байгаа нөхцөлд аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газраас авсан зөвшөөрөл, холбогдох дүгнэлт;
- 2.2.7. Газрын тухай хуулийн 39.1.3-т заасны дагуу тухайн байгууллагын газар эзэмших эрхийг дуусгавар болгосон тухай Засаг даргын шийдвэр, холбогдох материал;
- 2.2.8. Улсын тусгай хамгаалалттай газар нутагт газар эзэмших болсон бол тухайн асуудлыг хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрөл, холбогдох бичиг баримт.
- 2.3. Тээврийн хэрэгслийн хувьд энэхүү журмын 2.1-д зааснаас гадна дараах баримт, мэдээллийг ирүүлнэ;
- 2.3.1. Тээврийн хэрэгслийн гэрчилгээ, техник ашиглалтын дэвтэр, авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаарын бохирдлын төлбөр төлөгчийн гэрчилгээний хуулбар;
- 2.3.2. Техникийн үзүүлэлт, 3 талаас нь авсан өнгөт фото зураг;
- 2.3.3. Төслийн шугамаар ашиглагдаж байсан бол гаалийн татвар төлөлтийн

- мэдээлэл, холбогдох баримт;
- 2.3.4. Ашиглалтын сүүлийн 3 жилийн сэргээн босголтын зардлын дүн;
- 2.3.5. Тээврийн хэрэгслийн хувийн хэргийн Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаарын бохирдлын төлбөрийг төлсөн болон техникийн үзлэгт орсон талаарх эрх бүхий этгээдийн хийсэн тэмдэглэл, гарын үсэг, тамга бүхий хэсгийн хуулбар;
- 2.3.6. Ашиглалтад орсон он, балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл болон бусад мэдээллийг холбогдох байгууллагаас баталсан Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн бүртгэлийн мэдээллийн “Тээврийн хэрэгслийн маягт”-ын дагуу бүрдүүлсэн материал;
- 2.4. Механизм, тоног төхөөрөмжийн хувьд энэхүү журмын 2.1, 2.3-т зааснаас гадна дараах баримт, мэдээллийг ирүүлнэ;
- 2.4.1 Механизм, тоног төхөөрөмжийн ашиглалтын паспортын хуулбар;
- 2.4.2 Барилга байгууламжид суурилагдсан бол холбогдох мэдээлэл;
- 2.4.3 Бусад шаардлагатай баримт материал;
- 2.5. Биет бус хөрөнгийн хувьд 2.1-д зааснаас гадна дараах баримт, мэдээллийг ирүүлнэ;
- 2.5.1. Биет бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй “газар эзэмших эрх”-ийн асуудлыг шийдвэрлүүлэхэд газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ, кадастрын зураг, тухайн газар дээрх барилга, байгууламжийн жагсаалт шилжих болсон үндэслэл, шалтгааны тайлбар;
- 2.5.2. Тусгай зөвшөөрөл, патент, лиценз бүхий биет бус хөрөнгийн эрхийн бичгийн хуулбар, актлах, устгах, шилжүүлэх болсон үндэслэл
- 2.5.3. Программ хангамжийн нэр, үнэ элэгдэл, хорогдол, лиценз эзэмшигч болон ашиглалтын талаарх мэдээллийн жагсаалт;
- 2.6. Хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах шилжүүлэхдээ 2.1, 2.2, 2.3, 2.4, 2.5-т заасан материалыг бүрдүүлээгүй бол хөрөнгийг шийдвэрлэхийг хориглоно. Баримтын бүрдэлгүй хөрөнгийн шийдвэрийг хүчингүйд тооцно.

Гурав. Орон нутгийн өмчит хуулийн этгээд эд хөрөнгө олж авах

- 3.1. Орон нутгийн өмчит хуулийн этгээд нь эд хөрөнгийг эрх бүхий байгууллагаас баталсан төсөв, улсын болон орон нутгийн батлагдсан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу худалдаж авах, үйлдвэрлэл, ажил үйлчилгээний үр дүнд бий болгох, эсхүл иргэн, хуулийн этгээдээс үнэ төлбөргүй шилжүүлж авах, түүнчлэн хандив, тусламж, бэлэглэл, эрх залгамжлах журмаар олж авна.
- 3.2. Орон нутгийн өмчит хуулийн этгээд нь өөрийн чиг үүрэг, зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай эд хөрөнгийн жагсаалтыг бэлтгэн саналаа жил бүрийн 11 дүгээр сарын 15-ны дотор аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэст ирүүлэн хянуулж, холбогдох байгууллагаар батлуулна.
- 3.3. Орон нутгийн өмчит хуулийн этгээдэд эд хөрөнгө худалдан авах зөвшөөрөл олгох, үнийн дээд хязгаарыг тогтоохдоо эрх бүхий байгууллагаас баталсан төсөв болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгасан эх үүсвэрийг баримтална.
- 3.4. Орон нутгийн өмчит хуулийн этгээд тээврийн хэрэгсэл худалдан авах тухай бүрд Орон нутгийн өмчийн газраас зөвшөөрөл авна. Ийнхүү зөвшөөрөл олгохдоо эрх бүхий байгууллагаас тогтоосон тоо, төрлийг харгалзан үзнэ.

3.5. Төрийн байгууллага, албан газар, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар нь ажлын зайлшгүй хэрэгцээ шаардлагаар эд хөрөнгө худалдаж авах тохиолдолд санхүүгийн эх үүсвэрээ эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлсний дараа Орон нутгийн өмчийн газарт саналаа ирүүлэн зөвшөөрөл авна.

3.6. Эрчим хүч, уул уурхай, авто замын салбарын орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаанд онцгой нөхцөл байдал үүссэний улмаас хэвийн, тасралтгүй үйл ажиллагааг хангах шаардлагаар эд хөрөнгө худалдан авах тохиолдолд тодорхой үндэслэл, хөрөнгийн эх үүсвэрийн саналаа Орон нутгийн өмчийн газарт тавьж, зохих зөвшөөрөл авна.

3.7. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн үйл ажиллагаа, чиг үүрэгт өөрчлөлт орсон, ажлын цар хүрээ нэмэгдсэн, багассан, бүтцийн өөрчлөлт хийснээс шалтгаалан суудлын автомашин нэмж авах, цөөрүүлэх зайлшгүй шаардлага гарвал автомашины тоо, төрөл тогтоосон шийдвэрт өөрчлөлт оруулах тухай саналаа Орон нутгийн өмчит газарт хянуулж зөвшөөрөл авна.

3.8. Орон нутгийн өмчит хуулийн этгээд автомашин шинээр худалдан авах санал ирүүлэхдээ илүүдэлтэй эсхүл ашиглалтын шаардлага хангахгүй автомашиныг худалдах, шилжүүлэх, актлах асуудлыг хамтад нь тавьж шийдвэрлүүлнэ.

3.9. Орон нутгийн өмчит хуулийн этгээд нь газар эзэмших эрх шинээр авах саналаа аймаг, сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулан холбогдох газрын алба, сумын газрын даамалд хүсэлт гарган хянуулж, холбогдох байгууллагаар шийдвэрлүүлнэ.

3.10. Газар эзэмших, ашиглах эрх үүсмэгц түүнийг үнэлж, санхүүгийн тайланд бүртгэх саналыг Орон нутгийн өмчийн газарт хянуулж зөвшөөрөл авна.

Дөрөв. Орон нутгийн өмчит хуулийн этгээд эд хөрөнгийг бүртгэх

4.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ болон хандив, бэлэглэл, тусламжийн хүрээнд бий болсон хөрөнгийг санхүүжилтийн гүйцэтгэлээр эрх бүхий байгууллагын албан бичиг, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт дахь хөрөнгө тус бүрийн үнийн задаргааг харгалзан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох журамд заасны дагуу монгол хэлээр, зөв оновчтой нэршлээр данс бүртгэлд тусгана.

4.1.1. Батлагдсан эх үүсвэрээр бэлтгэсэн болон хандив, тусламж, бэлэглэл, төслийн шугамаар бий болсон хөдлөх хөрөнгийг бүртгэлд тусгахдаа Орон нутгийн өмчийн газраас зөвшөөрөл авах шаардлагагүй. Хандив, тусламж, бэлэглэлийн хүрээнд бий болсон хөрөнгийг үнэлэх шаардлага гарсан тохиолдолд Орон нутгийн өмчийн газартай зөвшилцөж болно.

4.1.2. Батлагдсан эх үүсвэрээр бэлтгэж буй үл хөдлөх хөрөнгийг аймгийн Засаг даргын тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтсээс, санхүүжилтийн гүйцэтгэл, хөрөнгийн жагсаалт, холбогдох бусад баримтыг аль нэг эсвэл хэд хэдэн хуулийн этгээдэд эзэмшүүлэх саналын хамт Орон нутгийн өмчийн газарт ирүүлж, бүртгэлд тусгах, эзэмшигчийг тогтоолгох асуудлыг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлнэ.

4.1.3. Хандив, тусламж, бэлэглэл, төсөл, хөтөлбөрийн хүрээнд хөрөнгийг хүлээн авч буй хуулийн этгээд тухайн иргэн, хуулийн этгээдийн зөвшөөрлийг албан ёсоор авч үндсэн хөрөнгө, эргэлтийн хөрөнгөөр нь ангилан, ашиглах хугацаа, чанар байдлыг нь харгалзан ашигласан хугацааны элэгдэл хорогдлын шимтгэлийг тооцож, данс бүртгэлдээ тусгана.

4.1.4. Орон нутгийн өмчит хуулийн этгээд улсын болон орон нутгийн төсвийн

хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сан, автозамын сан, зээл тусламж, хандиваар бий болсон үндсэн хөрөнгийг бүртгэхэд үнэ өртөг, эзэмших хуулийн этгээд тодорхойгүй болон маргаантай тохиолдолд Орон нутгийн өмчийн газарт асуудлаа тавьж холбогдох байгууллагаар шийдвэрлүүлнэ.

4.1.5. Зээлийн эх үүсвэрээр бий болсон хөрөнгийн хувьд уг зээлийн эргэн төлөлтийг хариуцах этгээдийг Сангийн яам, асуудлыг шийдвэрлэх эрх бүхий байгууллага болон холбогдох гэрээ хэлэлцээрээр тогтоосны үндсэн дээр бүртгэлд тусгах, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд эзэмшүүлэх асуудлыг Орон нутгийн өмчийн газарт тавьж, холбогдох байгууллагаар шийдвэрлүүлнэ.

4.2. Төсөвт хуулийн этгээд нь Төсвийн тухай хуулийн батлагдсан урсгал төсөв, нэмэлт төсөв, хэмнэсэн төсөв болон давсан орлогоос үндсэн хөрөнгө бүртгэх бол хэрэгцээ шаардлагаа тодорхойлж, зайлшгүй хэрэгцээтэй хөрөнгийн жагсаалт, тоо хэмжээ, худалдан авах үнийн дүнгийн дээд, доод хязгаарын саналыг дээд шатны төсвийн ерөнхийлөн захирагч дэмжсэн тохиолдолд энэ 2.2.3-т заасны дагуу Орон нутгийн өмчийн газар хянаж, зөвшөөрөл олгоно.

4.3. Орон нутгийн өмчит хуулийн этгээдэд төрийн болон орон нутгийн өмчид хамаарах хандив бэлэглэл, тусламжийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийг эзэмшүүлэх эсэх асуудлыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар шийдвэрлэх бөгөөд Орон нутгийн өмчийн газарт хүргүүлэн шийдвэрлүүлнэ.

4.4. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл арга хэмжээ болон хандив, бэлэглэл, тусламжийн хүрээнд бий болсон эд хөрөнгийг ашиглалтад хүлээн авсан актыг үндэслэн, эцсийн гүйцэтгэлийн дүнгээр Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох журамд заасны дагуу үнэлж, эргэлтийн болон үндсэн хөрөнгийн холбогдох данс бүртгэлд заавал тусгана.

4.5. Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан **“Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”**-ын 5.3.3-т заасны дагуу улсын хөрөнгө оруулалтаар барьсан барилга, байгууламжийг барьж дуусгах хүртэл захиалагч байгууллагыг төлөөлж, аймгийн Засаг даргын Тамгын газар нь “бусад эргэлтийн хөрөнгө” дансанд бүртгэн санхүүгийн тайланд тусгана. Улсын комисс барилга байгууламжийг байнгын ашиглалтад хүлээн авсан актыг үндэслэн, захиалагч нь газар үл хөдлөх хөрөнгийг төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд эзэмшүүлэх саналыг орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн бол Орон нутгийн өмчийн газарт, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн бол төрийн өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлэн шийдвэрлүүлснээр эзэмшигч байгууллагын данс бүртгэлд бүртгэнэ.

4.6. Үндсэн хөрөнгийн дансанд Нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандартын “хүлээн зөвшөөрөлтийн зарчим” хангагдсан үндсэн хөрөнгийн шинжийг хадгалсан хөрөнгийг бүртгэнэ

4.7. Улсын болон орон нутгийн төсөв, хандив бэлэглэл, тусламжийн хүрээнд бий болсон хөрөнгийг тухайн орон нутгийн өмчит байгууллага ашиглаж байгаа боловч данс бүртгэлд тусгаагүй бол түүнийг зөрчил гэж үзэх бөгөөд хөрөнгийг данс бүртгэлд тусгах асуудлыг Орон нутгийн өмчийн газарт нэн даруй тавьж зөвшөөрөл авч бүртгэлд тусгана.

4.8. Төсөвт байгууллагын зөвшөөрөлгүй бэлтгэсэн үндсэн хөрөнгийг хураан авч хэрэгцээ, шаардлага гарсан байгууллагад шилжүүлэх асуудлыг Орон нутгийн өмчийн газар эрх бүхий этгээдэд санал хүргүүлэн шийдвэрлүүлнэ.

4.9. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд улсын төсвийн хөрөнгө оруулалт, зээл, тусламж, хандиваар бий болсон хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэхэд үнэ өртөг, эзэмших хуулийн этгээд нь тодорхойгүй болон

маргаантай тохиолдолд төрийн өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад асуудлаа тавьж шийдвэрлүүлнэ.

4.10. Эрх бүхий байгууллагаас баталсан төсөв, улсын болон орон нутгийн баталсан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу худалдаж авах, үйлдвэрлэл, ажил үйлчилгээний үр дүнд бий болгох, эсхүл иргэн, хуулийн этгээдээс үнэ төлбөргүй шилжүүлж авах, түүнчлэн хандив, тусламж, бэлэглэл, эрх залгамжлах журмаар бий болсон хөрөнгийг бүртгэлд тусгахдаа улсын комиссын акт, анхан шатны бичиг баримтыг үндэслэн бүртгэлд тусгана. Анхан шатны бичиг баримтын бүрдэлгүй хөрөнгийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-д заасны дагуу бүртгэхийг хориглоно. Дээрх эх үүсвэрээр бий болсон хөрөнгийн анхан шатны бичиг баримтын бүрдүүлэлтийг тухайн хөрөнгийг хүлээж авсан ажилтан, нягтлан бодогч нар хариуцна.

4.11. Төрийн өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, бусад аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр аймгийн орон нутгийн өмчид үнэ төлбөргүй шилжүүлсэн хөрөнгийг хүлээн авч, орон нутгийн өмчид бүртгэхдээ дараах материалыг бүрдүүлэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар эзэмшигчийг тогтоолгоно.

4.11.1. Шилжүүлсэн хөрөнгийн нэр төрөл, байршил, чанар байдлыг тодорхой тусгасан хөрөнгийг шилжүүлэх тухай аймаг нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, төрийн өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын шийдвэр;

4.11.2. Төрийн өмч, бусад аймаг нийслэлээс орон нутгийн өмчид шилжүүлэх хөрөнгийг хүлээн авч, данс бүртгэлдээ тусгах орон нутгийн өмчит хуулийн этгээдийн зөвшөөрөл, өмч эзэмшигч орон нутгийн өмчит болон төрийн өмчит байгууллагын санал;

4.11.3. Үл хөдлөх хөрөнгө шилжүүлэх тохиолдолд тухайн үл хөдлөх хөрөнгийн доорх газар "газар эзэмших эрх" (биет бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй)-ийн үнэлгээ, эрхийн гэрчилгээ, кадастрын зураг болон уг эрхийг бусад өмчийн этгээдэд шилжүүлэх асуудлаар аймаг, сумын Засаг даргын санал, зөвшөөрөл.

Тав. Эд хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх

5.1. Эрх бүхий байгууллагын шийдвэрээр болон бусад шаардлагаар орон нутгийн өмчит хуулийн этгээд илүүдэлтэй буюу ашигладаггүй эд хөрөнгийг шилжүүлэх, бусад байгууллагын өмчлөлд байгаа эд хөрөнгийг балансаас балансад шилжүүлэн авахдаа өмч эзэмшигч байгууллагын зөвшөөрлийг авч, холбогдох баримт материалыг энэхүү журамд заасны дагуу бүрдүүлэн Орон нутгийн өмчийн газарт ирүүлж хянуулна.

5.2. Орон нутгийн өмчөөс төрийн өмчид хөрөнгө шилжүүлэхдээ, хөрөнгийг шилжүүлэн авч буй төрийн өмчит байгууллага, төрийн өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас хөрөнгийг бүртгэлд авах зөвшөөрлийг заавал авсан байна.

5.3. Орон нутгийн өмчит хуулийн этгээд нь холбогдох эрх бүхий байгууллагын шийдвэрт зааснаар хөрөнгө хүлээлцэх ажлыг зохион байгуулж, баланс тайланд хөдлөл өөрчлөлтийг тусгана.

5.4. Үл хөдлөх хөрөнгө болон их хэмжээний хөдлөх үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх тохиолдолд Орон нутгийн өмчийн газрын даргын тушаалаар ажлын хэсэг байгуулан, хөрөнгө хүлээлцэх ажлыг зохион байгуулж болно.

5.5. Эд хөрөнгө шилжүүлэхтэй холбогдон гарах зардлыг хөрөнгө шилжүүлж авсан байгууллага хариуцна.

5.6. Үл хөдлөх хөрөнгө шилжүүлж өгсөн этгээд өөрийн эзэмшилд байгаа эзэмших, ашиглах эрхтэй газраас, шилжүүлэх үл хөдлөх хөрөнгөд ноогдох газрын хэсгийг хэмжиж зураглал хийлгэн, хөрөнгө хүлээн авах хуулийн этгээдтэй хамтран Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын зөвшөөрлийг авна. Уг зөвшөөрлийг үндэслэн газрын гэрчилгээ, кадастрын зураг, гэрээнд өөрчлөлт оруулж, шилжүүлэн авсан хуулийн этгээд өөрийн нэр дээр газар эзэмших эрхийг шилжүүлэх арга хэмжээ авна.

5.7.Элэгдэл хорогдлын шимтгэлээрээ өртгөө нөхсөн хөрөнгийг шилжүүлэх асуудлыг шийдвэрлэхдээ энэ журмын 7.1-д заасны дагуу тухайн хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг энэ тогтоолын 2.2.2-т заасны дагуу Орон нутгийн өмчийн газарт хүргүүлж шийдвэрлүүлнэ.

Зургаа. Эд хөрөнгийг акталж, данснаас хасах

6.1.Орон нутгийн өмчит хуулийн этгээд нь хагас болон бүтэн жилийн эд хөрөнгийн тооллогын дүн, өмч хамгаалах Байнгын зөвлөлийн дүгнэлтээр цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон нь тогтоогдсон үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах саналаа энэ журамд заасан баримт материалын хамт Орон нутгийн өмчийн газарт хүргүүлж, холбогдох байгууллагаар шийдвэрлүүлнэ.

6.2.Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг дараах тохиолдолд эрх бүхий байгууллагын шийдвэрээр данснаас хасна.

- 6.2.1. Элэгдлийн нийт хэмжээ, ашиглалтын хугацаагаараа балансын үнээ бүрэн нөхсөн бөгөөд цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон;
- 6.2.2. Ашиглалтын хугацаа нь дуусаагүй боловч ашиглах явцад хэн нэгний буруутай үйлдлээс болж эвдэрч гэмтэн цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын дүгнэлт гаргуулан буруутай этгээдээр хохирлыг барагдуулсан тохиолдолд;
- 6.2.3. Техник, технологийн болон хэрэглээний хоцрогдолд орж, зайлшгүй шинэчлэх шаардлагатай болсон;
- 6.2.4. Балансын үнээ бүрэн нөхөөгүй боловч байгалийн гэнэтийн аюул, техникийн осолд өртсөнөөс цаашид зориулалтын дагуу ашиглах боломжгүй болсон;
- 6.2.5. Ашиглалтын явцад эвдэрч гэмтсэнээс засвар шинэтгэл хийж ашиглахад эдийн засгийн хувьд үр ашиггүй болох нь тооцоогоор нотлогдсон.

6.3. Орон нутгийн өмчит хуулийн этгээд эд хөрөнгө актлах саналаа сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Орон нутгийн өмчийн газарт хүргүүлэхдээ энэхүү журамд заасан мэдээллээс гадна дараах зүйлийг заавал тусган хүснэгтээр илэрхийлсэн байна.

- 6.3.1. Данснаас хасах эд хөрөнгийн нэр, тодорхойлолт;
- 6.3.2. Тоо хэмжээ;
- 6.3.3. Данснаас хасах болсон шалтгаан;
- 6.3.4. Уг эд хөрөнгийг акталж устгах, эсвэл акталж сэлбэгээр ашиглах тухай санал;
- 6.3.5. Өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хурлын тэмдэглэл, дүгнэлт;
- 6.3.6. Байгалийн гэнэтийн аюул, техникийн осол, гэмтэлд өртсөн эд хөрөнгийн шалтгааны тухай холбогдох байгууллагын акт дүгнэлт.

6.4. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг дарга, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь эд хөрөнгийг акталж, данснаас хасахдаа дараах хэлбэрээр шийдвэрлэнэ.

6.4.1 Эд хөрөнгийг худалдах;

6.4.2 Орон нутгийн өмчит болон төрийн өмчит, бусад хуулийн этгээдэд шилжүүлэх;

6.4.3 Сэлбэг, материал, хоёрдогч түүхий эд болгон ашиглах буюу худалдах;

6.4.4 Шууд устгах;

6.4.5 Барилга байгууламжийн хувьд тухайн газрыг цаашид ашиглах зориулалтын талаар чиглэл өгөх;

6.4.6 Газар дээрх болон газар доорх барилга байгууламжийг буулгах, ашиглаж болох материалыг үнэ тогтоон орлогод авах, хог хаягдлыг цэвэрлэх, газрыг нөхөн сэргээх.

6.5. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг даргын шийдвэрээр эд хөрөнгийг акталж худалдахаар шийдвэрлэсэн тохиолдолд Орон нутгийн өмчийн газраас худалдах ажлыг зохион байгуулна.

6.6. Аймгийн Засаг даргаас зарим байгууллагад хөрөнгийг худалдах эрхийг олгосон бол хөрөнгийн үнэлгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, хөрөнгө худалдах ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөл зохион байгуулна.

6.7. Хөрөнгө акталж, худалдах шийдвэрт худалдах үнийг заасан бол түүнээс багагүй үнээр, худалдах үнийг заагаагүй бол байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлөөс үнийг тогтоож худалдах ажлыг зохион байгуулна.

6.8. Орон нутгийн өмчид бүртгэлтэй тээврийн хэрэгсэл, машин механизмыг акталж, худалдахаар шийдвэрлэсэн бол тэдгээр хөрөнгийг авто тээврийн хэрэгслийн улсын бүртгэл болон татвар төлөгчийн бүртгэлээс хасуулах арга хэмжээ авна.

6.9. Акталсан тээврийн хэрэгслийг сэлбэгээр худалдан авсан этгээдэд тээврийн хэрэгслийн улсын дугаарыг шилжүүлэхийг хориглоно.

6.10. Орон нутгийн өмчит хуулийн этгээд акталж, хоёрдогч түүхий эд сэлбэгээр худалдсан орлогыг тухайн байгууллагын дансанд, дуудлага худалдаагаар худалдсан орлогоос худалдан борлуулахтай холбогдон гарсан зардлыг хассан дүнгээр "Орон нутгийн өмч худалдсаны орлого" дансанд, орон нутгийн өмчит компани болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь акталсан, худалдсан хөрөнгийн орлогыг өөрийн дансанд төвлөрүүлнэ.

Долоо. Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох

7.1. Орон нутгийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэлтэй болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтсэн, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн энэ хүү тогтоолын 2.2.2-т заасны дагуу Орон нутгийн өмчийн газарт ирүүлж шийдвэрлүүлнэ.

7.2. Эрх бүхий байгууллагын шийдвэрээр акталж, данснаас хасахаар шийдвэрлэж, зөвшөөрөл авсан боловч ашиглалтын шаардлага хангаж байгаа, дахин ашиглах боломжтой хөрөнгийн үнийг Орон нутгийн өмчийн газартай зөвшилцөн тогтоож, дахин данс бүртгэлдээ тусгана.

7.3. Орон нутгийн өмчит хуулийн этгээд нь энэ журмын 7.1, 7.2-д заасан асуудлаар санал бэлтгэн Орон нутгийн өмчийн газарт ирүүлэхдээ дараах баримт материалыг хамт ирүүлнэ.

7.3.1. Ашиглалтын хугацаа дуусаагүй, үлдэгдэл өртөгтэй боловч ашиглах

боломжгүй болсон үндсэн хөрөнгийн эвдрэл, гэмтлийн шалтгааныг тогтоосон дүгнэлт, сэргээн засварлаж ашиглахад шаардагдах эдийн засгийн тооцоо үндэслэл;

- 7.3.2. Эрх бүхий байгууллагаас гарсан данснаас хасах шийдвэр;
- 7.3.3. Эрх бүхий байгууллагаар хийлгэсэн хөрөнгийн үнэлгээ; (байгаа бол)
- 7.3.4. Хөрөнгийн ашиглалтын талаар гаргасан мэргэжлийн байгууллагын дүгнэлт; (байгаа бол)
- 7.3.5. Ашиглалтын хугацааг сунгах, үнийг шинэчлэн тогтоох асуудлыг хэлэлцсэн өмч хамгаалах Байнгын зөвлөлийн тэмдэглэл, дүгнэлт
- 7.3.6. Хөрөнгийн жагсаалт;
- 7.3.7. Бусад шаардлагатай материал.

Найм. Орон нутгийн өмчит хуулийн этгээд эд хөрөнгө олж авах, бүртгэх, шилжүүлэх, худалдах, акталж данснаас хасах шийдвэрийг хэрэгжүүлэх, тайлагнах

8.1. Орон нутгийн өмчит хуулийн этгээд нь эд хөрөнгө олж авах, бүртгэх, шилжүүлэх, акталж данснаас хасах тухай аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг дарга, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийг өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хэрэгжүүлнэ.

8.2. Орон нутгийн өмчит хуулийн этгээд нь шийдвэрийн биелэлтийг холбогдох материалын хамт тогтоосон хугацаанд Орон нутгийн өмчийн газарт тайлагнана.

8.3. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг акталж сэлбэг материал, хоёрдогч түүхий эд болгон ашиглах буюу худалдах, данснаас хасах шийдвэрийн хэрэгжилтийг устгалын акт, эргэлтийн хөрөнгөд орлого болгосон тэмдэглэл, худалдсан тухай акт хэлбэрээр баталгаажуулан, гүйцэтгэлийн үр дүнг холбогдох данс бүртгэлд тусгана.

8.4. Орон нутгийн өмчит хуулийн этгээд олж авсан, бүртгэсэн, шилжүүлсэн, худалдсан, акталсан эд хөрөнгийн хөдлөлийн нэгдсэн тайланг жил бүр эрх бүхий байгууллагаас баталсан төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн бүртгэлийн мэдээллийн “үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийн жилийн мэдээ” маягтын дагуу гаргаж Орон нутгийн өмчийн газарт хүргүүлнэ.

Ес. Бусад

9.1. Эрх бүхий байгууллагын шийдвэр, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу хийсэн үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний үр дүн болон хөрөнгийн үнэлгээний залруулгыг данс бүртгэлд тусгах асуудлыг эрх бүхий байгууллагаас гарсан заавар, журмын дагуу шийдвэрлэнэ.

9.2. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй хөрөнгийн элэгдлийн хугацаа, хэмжээг тооцохдоо Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баримтална.

9.3. Орон нутгийн өмчийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх хүртэлх хугацаанд тухайн эд хөрөнгийн иж бүрдэл, чанар байдал, бүрэн бүтэн байдлыг тухайн байгууллагын удирдлага хариуцна.

9.4. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлага нь эд хөрөнгийг харуул хамгаалалтаар хангах бөгөөд дутагдал, зөрчил гарсан тохиолдолд “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”, “Зөрчлийн тухай хууль” болон холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээнэ.